Улаанбаатар хотын оюутнуудын цахим сургалтын байдлыг тодорхойлсон дүн

Ч.Мягмарчимэг[1], Ц.Тамираа[2], Б.Билэгт[3]

[1 2]Этүгэн их сургууль, Эрүүл мэндийн сургууль
[3]АШУҮИС, Нийгмийн эрүүл мэндийн сургууль
Цахим шуудан: chimgeemerik@gmail.com, Утас: 99227877

Түлхүүр үг:

Сэтгэл ханамж
Бэлтгэлд зарцуулах цаг
Хамрагдахад зарцуулах цаг
Бэрхшээл
Эерэг нөлөө

Товч утга:

Үндэслэл: Технологийн хурдацтай хөгжил нь амьдрах, суралцах, ажиллах арга барилыг бүхэлд нь өөрчлөх шаардлага зүй ёсоор тавигдаж уламжлалт аргаас татгалзаж шинэлэг арга технологийг ашиглан илүү уян хатан байж хурдацтайгаар дасан зохицохыг шаардах болсон юм. Цахим сургалтын байдал болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан судалгаа одоогоор ховор байгаа нь бидний судалгааны ажлын үндэслэл болсон юм. **Зорилго:** Улаанбаатар хотын оюутан залуусын цахим сургалтын байдал болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судлахыг зорьсон. **Арга, аргачлал:** Улаанбаатар хотод оюутнуудаас 990 оюутныг хамруулсан, судалгааг 30 асуулт бүхий асуулгыг ашиглан хийсэн ба нэг болон хоёр түүврийн Т тест, олон хүчин зүйлийн тестээр үнэлэв. **Үр дүн:** Судалгаанд хамрагдагсдын дийлэнх буюу 82.5% нь цахим сургалтанд сэтгэл ханамжтай байв. Оюутнуудын дийлэнх нь цахим сургалтанд хамрагдахад (40%) 5 ба түүнээс дээш цаг зарцуулдаг бол бэлтгэл хангахад (31.2%) 1-2 цаг зарцуулдаг байна. Цахим сургалтанд хамрагдахад цаг их зарцуулж байгаа нь зонхилох бэрхшээл болж байсан (52.9%) бол бие даан суралцах чадвар нэмэгдсэн (48.5%) нь зонхилох эерэг нөлөө байв. **Дүгнэлт:** Нийт судалгаанд хамрагдагсдын цахим сургалтын сэтгэл ханамжийн түвшин, сургалтанд хамрагдахад болон бэлтгэл хангахад зарцуулж буй цаг, сургалтанд хамрагдахад тулгарч буй бэрхшээл болон эерэг нөлөө зэргийг насны бүлэг, хүйсийн байдлаар харьцуулан судлахад статистик ач холбогдол бүхий ялгаатай $P<0.05$ байсан бол тулгарч буй бэрхшээлүүдээс багаар ажиллах чадвар буурсан үзүүлэлт нь насны хувьд статистик ач холбогдол бүхий ялгаагүй $P>0.05$ байв.

Үндэслэл: Технологийн хурдацтай хөгжил нь амьдрах, суралцах, ажиллах арга барилыг бүхэлд нь өөрчлөх шаардлага зүй ёсоор тавигдаж уламжлалт аргаас татгалзаж шинэлэг арга технологыг ашиглан илүү уян хатан байж хурдацтайгаар дасан зохицохыг шаардаж байна.[1]

Дэлхий дахинд цахим сургалт эрчимтэй хөгжиж байгаа хэдий ч түүнийг даган хувьсах хурд улс орон бүрт харилцан адилгүй байна. Ялангуяа газар зүй, эдийн засаг, хэл шинжлэлийн саад бэрхшээлээс үүдэлтэй тэгш бус байдал үүсч улмаар дижитал хуваагдлыг үүсгэж байгааг олон судлаачид дурьджээ.[2]

Монгол Улсын хувьд 2005 онд Монгол Улсын Засгийн Газраас гаргасан Цахим Монгол Үндэсний хөтөлбөрийн нэг зорилт нь “Зайн сургалт” юм. Гэвч энэхүү зорилтыг биелүүлэхийн тулд үндэсний хэмжээнд төдийлөн дорвитой арга хэмжээ аваагүй, зөвхөн зарим их, дээд болон дунд сургуулиуд, төрийн бус байгууллагууд, компаниуд өөрсдийн боломжийн хэрээр онлайн сургалтыг хөгжүүлэхээр мэрийн ажиллаж байгааг судлаачид цөөнгүй тэмдэглэсэн байна.[3]

Т.Уранчимэг нарын судлаачид 2020 онд эм зүйн мэргэжлээр суралцаж буй 552 оюутны дунд цахим хичээлийн гүйцэтгэлийг судлахад нийт судалгаанд хамрагдагсдын 28.8% нь хичээлийн үнэлгээг сайн гэж үнэлсэн байна.[4]

Б.Буяндэлгэр нарын судлаачид 2022 онд Мэргэжил сургалт үйлдвэрлэлийн төвийн суралцагчид болон багш нарын цахим сургалтанд бэлэн байдлыг

судлахад дундаж түвшинтэй байжээ.[5]

Манай оронд оюутан залуусын дунд цахим сургалтын гүйцэтгэл болон бэлэн байдлыг үнэлсэн судалгаа хийгдсэн болов ч цахим сургалтын байдал болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг судалсан судалгаа ховор байгаа нь бидний судалгааны ажлын үндэслэл боллоо.

Зорилго: Улаанбаатар хотын оюутан залуусын цахим сургалтын байдал болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийг тодорхойлох.


Зорилт:

1. Улаанбаатар хотын оюутнуудын цахим сургалтын байдлыг судлах
2. Улаанбаатах хотын оюутнуудын цахим сургалтын байдлыг зарим үзүүлэлтээр харьцуулан судлах

Арга, аргачлал: Бид Улаанбаатар хотод орших 26 их дээд сургуулиудын оюутнуудаас санамсаргүй түүвэрлэлт хийж нас болон хүйсийн хувьд төлөөлөх чадвартай байхаар 990 оюутныг сонгон авч судалгаандаа хамруулав.

Судалгаанд хамрагдагсдын цахим сургалтын байдлыг үнэлэх зорилгоор 30 асуулт бүхий асуулгын хуудас боловсруулсан. Судалгааг тохиолдолд суурилсан судалгааны аргаар хийсэн. Цахим сургалтын байдлыг зарим үзүүлэлтээр харьцуулан судалж тоон мэдээллийг таамаглал шалгах T тест, бүлэглэгдсэн мэдээллүүдийн хоорондох ялгааг Хи-Квадрат тестээр тус тус үнэлэв.

Үр дүн: Судалгаанд хамрагдсан нийт оюутны 402 (40.6%) нь эрэгтэй, 588 (59.4%) нь эмэгтэй оюутан байсан ба дундаж нас нь 21±1 жил байв. Судалгаанд нийт хамрагдагсдын 2.4% нь цахим сургалтын сэтгэл ханамж муу, 15.1% нь дунд, 54% нь сайн, 28.5% нь маш сайн хэмээн үнэлжээ. (Зураг 1)



Зураг 1. Оюутнуудын цахим сургалтын сэтгэл ханамжийн түвшин

Судалгаанд хамрагдсан эрэгтэй оюутнуудын 1.5% нь цахим сургалтын сэтгэл ханамж муу, 6.7% нь дунд, 49% нь сайн, 42.8% нь маш сайн гэж үнэлсэн бол эмэгтэй оюутнуудын 3.1% нь муу, 20.7% нь дунд, 57.5% нь сайн, 18.7% нь маш сайн гэж үнэлсэн байна. Цахим сургалтын сэтгэл ханамжийг хүйсийн байдлаар харьцуулан судлахад маш сайн гэж үнэлсэн оюутнуудын дунд эрэгтэй оюутнуудын эзлэх хувь өндөр буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай P=0.001 байна. Цахим сургалтын сэтгэл ханамжийг насны бүлгээр харьцуулан судлахад 17-19 насны бүлгийн оюутнуудын 2.8% нь сэтгэл ханамж муу, 20.5% нь дунд, 48.3% нь сайн, 28.5% нь маш сайн гэж үнэлсэн бол 20-22 насны бүлгийн оюутнуудын 2.6% нь муу, 12.9% нь дунд, 55.3% нь сайн, 29.2% нь маш сайн гэж үнэлсэн. Мөн 23-25 насны бүлгийн оюутнуудын 0.8% нь муу, 9.8% нь дунд, 63.9% нь сайн, 25.4% маш сайн гэж үнэлсэн байна. Цахим сургалтын сэтгэл ханамжийг насны бүлгээр харьцуулан судлахад сайн гэж үнэлсэн оюутнуудын дунд 23-25 насны оюутнуудын эзлэх хувь өндөр буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай P=0.01 байв. (Хүснэгт 1)

Хүснэгт 1. Оюутнуудын сэтгэл ханамжийн түвшин насны бүлэг болон хүйсээр

Үзүүлэлт	Сэтгэл ханамжийн түвшин								P утга
	Муу		Дунд		Сайн		Маш сайн		
	n	%	n	%	n	%	n	%	
Хүйс									**0.001**
Эрэгтэй	6	1.5%	27	6.7%	197	49%	172	42.8%	
Эмэгтэй	18	3.1%	122	20.7%	338	57.5%	110	18.7%	
Насны бүлэг									**0.01**
17-19 нас	9	2.8%	67	20.5%	158	48.3%	93	28.4%	
20-22 нас	14	2.6%	70	12.9%	299	55.3%	158	29.2%	
23-25 нас	1	0.8%	12	9.8%	78	63.9%	31	25.4%	

Судалгаанд хамрагдагсдын 1.7% нь цахим сургалтанд хамрагдахад 1 ба түүнээс бага цаг, 9.8% нь 1-2 цаг, 15.6% нь 2-3 цаг, 32.9% нь 3-4 цаг, 40% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байсан бол цахим сургалтын бэлтгэлд 26.6% нь 1 ба түүнээс бага цаг, 31.2% нь 1-2 цаг, 12.9% нь 2-3 цаг, 14.9% нь 3-4 цаг, 14.3% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байв. (Зураг 2)



Зураг 2. Цахим сургалтанд хамрагдахад болон бэлтгэлд зарцуулж буй цаг

Судалгаандхамрагдсанэрэгтэйоюутнуудын 2.5% нь цахим сургалтанд хамрагдахад 1 ба түүнээс бага цаг, 7% нь 2-3 цаг, 15.9% нь 3-4 цаг, 37.8% нь 4-5 цаг, 36.8% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байгаа бол эмэгтэй оюутнуудын 1.2% нь 1 ба түүнээс бага цаг, 11.7% нь 2-3 цаг, 15.3% нь 3-4 цаг, 29.6% 4-5 цаг, 42.2% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байна. Цахим сургалтанд хамрагдахад зарцуулж буй цагийг хүйсийн байдлаар харьцуулан судлахад ач холбогдол бүхий ялгаатай P=0.006 байна.

Цахим сургалтанд хамрагдахад зарцуулж буй цагийг насны бүлгээр харьцуулан судлахад 17-19 настай оюутнуудын 1.2% нь 1 ба түүнээс бага цаг, 9.8% нь 1-2 цаг, 11.6% нь 2-3 цаг, 32.7% нь 3-4 цаг, 44.6% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байгаа бол 20-22 настай оюутнуудын 2% нь 1 ба түүнээс бага цаг, 9.4% нь 1-2 цаг, 17.7% нь 2-3 цаг, 32.5% нь 3-4 цаг, 38.3% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байна. Мөн 23-25 настай оюутнуудын 1.6% нь 1 ба түүнээс бага цаг, 11.5% нь 2-3 цаг, 16.4% нь 3-4 цаг, 32.5% нь 4-5 цаг, 38.3% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байна.

Цахим сургалтанд хамрагдаж буй цагийг насны бүлгээр харьцуулан судлахад 5 ба түүнээс дээш цаг зарцуулж буй оюутнуудын дунд 17-19 настай оюутнуудын эзлэх хувь өндөр буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай P=0.319 байна. (Хүснэгт 2)

Хүснэгт 2. Цахим сургалтанд хамрагдахад зарцуулж буй хугацааг тодорхойлсон дүн (хүйс, насны бүлгээр)

Үзүүлэлт	Цахим сургалтанд хамрагдахад зарцуулж буй цаг										P утга
	1-аас бага		2-3		3-4		4-5		5-аас дээш		
	n	%	n	%	n	%	n	%	n	%	
Хүйс											**0.006**
Эрэгтэй	10	2.5%	28	7%	64	15.9%	152	37.8%	148	36.8%	
Эмэгтэй	7	1.2%	69	11.7%	90	15.3%	174	29.6%	248	42.2%	
Насны бүлэг											**0.319**
17-19	4	1.2%	32	9.8%	38	11.6%	107	32.7%	146	44.6%	
20-22	11	2%	51	9.4%	96	17.7%	176	32.5%	207	38.3%	
23-25	2	1.6%	14	11.5%	20	16.4%	43	35.2%	43	35.2%	

Судалгаанд хамрагдсан эрэгтэй оюутнуудын 41% нь цахим сургалтын бэлтгэл хангахад 1 ба түүнээс бага цаг, 38.8% нь 1-2 цаг, 9% нь 2-3 цаг, 6.9% 3-4 цаг, 4.5% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байгаа бол эмэгтэй оюутнуудын 16.7% нь 1 ба түүнээс бага цаг, 26% нь 1-2 цаг, 15.6% нь 2-3 цаг, 20.6% 3-4 цаг, 21.1% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байна.

Цахим сургалтын бэлтгэл хангахад зарцуулж буй цагийг хүйсийн байдлаар харьцуулан судлахад 1-2 цаг зарцуулж буй оюутнуудын дунд эрэгтэй оюутнуудын эзлэх хувь өндөр бол 2 ба түүнээс дээш цаг зарцуулж буй оюутнуудын дунд эмэгтэй оюутнуудын эзлэх хувь өндөр буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай P=0.001 байна.


Цахим сургалтын бэлтгэл хангахад зарцуулж буй цагийг насны бүлгээр харьцуулан судлахад 17-19 настай оюутнуудын 24.8% нь 1 ба түүнээс бага цаг, 26% нь 1-2 цаг, 15% нь 2-3 цаг, 18.3% нь 3-4 цаг, 15.9% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байгаа бол 20-22 настай оюутнуудын 27.9% нь 1 ба түүнээс бага цаг, 34.4% нь 1-2 цаг, 11.8% нь 2-3 цаг, 14% нь 3-4 цаг, 11.8% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байна. Мөн 23-25 настай оюутнуудын 25.4% нь 1 ба түүнээс бага цаг, 31.1% нь 1-2 цаг, 12.3% нь 2-3 цаг, 9.8% нь 3-4 цаг, 21.3% нь 5 ба түүнээс дээш цаг зарцуулж байна.

Цахим сургалтын бэлтгэл хангахад зарцуулж буй цагийг насны бүлгээр харьцуулан судлахад 5 ба түүнээс дээш цаг зарцуулж буй оюутнуудын дунд 23-25 настай оюутнуудын эзлэх хувь өндөр буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай P=0.015 байна. (Хүснэгт 3)

Хүснэгт 3. Цахим сургалтын бэлтгэл хангахад зарцуулж буй хугацааг тодорхойлсон дүн (хүйс, насны бүлэг)

Үзүүлэлт	Цахим сургалтын бэлтгэл хангахад зарцуулж буй цаг										P утга
	1-аас бага		1-2		2-3		3-4		5-аас дээш		
	n	%	n	%	n	%	n	%	n	%	
Хүйс											**0.001**
Эрэгтэй	165	41%	156	38.8%	36	9%	27	6.7%	18	4.5%	
Эмэгтэй	98	16.7%	153	26%	92	15.6%	121	20.6%	124	21.1%	
Насны бүлэг											**0.015**
17-19	81	24.8%	85	26%	49	15%	60	18.3%	52	15.9%	
20-22	151	27.9%	186	34.4%	64	11.8%	76	14%	64	11.8%	
23-25	31	25.4%	38	31.1%	15	12.3%	12	9.8%	26	21.3%	

Нийт оюутнуудын 21.7% нь бие даан ажиллах чадвар дутмаг, 52.9% нь цахим сургалтанд зарцуулах цаг их, 34.2% нь багшийн заах арга зүй дутмаг, 44.1% нь багаар ажиллах чадвар буурсан, 33.2% нь баяр жаргалтай байх нь багассан, 50.4% нь оройтож унтаж оройтож сэрдэг болсон, 49.7% нь цахим сургалтын хэрэглэгдэхүүн дутмаг байгаа нь бэрхшээл болж байна хэмээн тодорхойлжээ. (Зураг 3)



Зураг 3. Цахим сургалтанд хамрагдахад оюутанд тулгарч буй бэрхшээлийг судалсан дүн

Судалгаанд хамрагдасан 17-19 настай оюутнуудын 23.5% нь цахим орчинд ажиллах чадвар дутмаг, 51.7% нь бие даан суралцах чадвар дутмаг, 49.8% нь цаг их зарцуулдаг, 21.1% нь багшийн заах арга зүй дутмаг, 40.7% нь багаар ажиллах чадвар буурсан, 30% нь баяр жаргал буурсан, 51.1% оройтож унтаж оройтож сэрдэг болсон бол 20-22 настай оюутнуудын 16.5% нь цахим орчинд ажиллах чадвар дутмаг, 44.7% нь бие даан суралцах чадвар дутмаг, 54.1% нь цаг их зарцуулдаг, 40.7% нь багшийн заах арга зүй дутмаг, 47.3% нь багаар ажиллах чадвар буурсан, 38.1% нь баяр жаргал буурсан, 53% нь оройтож унтаж оройтож сэрдэг болсон бол 23-25 настай оюутнуудын 10.7% нь цахим орчинд ажиллах чадвар дутмаг, 56.6% нь бие даан суралцах чадвар дутмаг, 42.6% нь цаг их зарцуулдаг, 41% нь багшийн заах арга зүй дутмаг, 39.3% нь багаар ажиллах чадвар буурсан, 20.5% нь баяр жаргал буурсан, 36.9% оройтож унтаж оройтож сэрдэг болсон байна.

Цахим сургалтанд хамрагдахад тулгарч буй бэрхшээлийг насны бүлгээр харьцуулан судлахад цахим орчинд ажиллах чадвар дутмаг, бие даан суралцах чадвар дутмаг, цаг их зарцуулдаг, багшийн заах арга зүй дутмаг, баяр жаргал буурсан, оройтож унтаж, оройтож сэрдэг болсон зэрэг үзүүлэлт нь статистик ач холбогдол бүхий ялгаатай P<0.05 байсан бол багаар ажиллах чадвар буурсан үзүүлэлт нь статистик ач холбогдол бүхий ялгаагүй (P=0.084) байна. (Хүснэгт 4)

Хүснэгт 4. Цахим сургалтанд хамрагдахад оюутанд тулгарч буй бэрхшээлийг тодорхойлсон дүн (насны бүлэг)

Тулгарч буй бэрхшээл	Насны бүлэг						P утга
	17-19 нас		20-22 нас		23-25 нас		
	n	%	n	%	n	%	
Цахим орчинд ажиллах чадвар дутмаг	77	23.5%	89	16.5%	13	10.7%	0.002
Бие даан суралцах чадвар дутмаг	169	51.7%	242	44.7%	69	56.6%	0.023
Цаг их зарцуулдаг	163	49.8%	309	54.1%	52	42.6%	0.006
Багшийн заах арга зүй дутмаг	69	21.1%	220	40.7%	50	41%	0.000
Багаар ажиллах чадвар буурсан	133	40.7%	256	47.3%	48	39.3%	0.084
Баяр жаргал буурсан	98	30%	206	38.1%	25	20.5%	0.018
Оройтож унтаж оройтож сэрдэг болсон	167	51.1%	287	53%	45	36.9%	0.005

Судалгаанд хамрагдсан эрэгтэй оюутнуудын 37.1% нь бие даан суралцах чадвар нэмэгдсэн, 26% нь давтан үзэх боломжтой, 12 % нь баяр жаргал нэмэгдсэн гэж үнэлсэн бол эмэгтэй оюутнуудын 56% нь бие даан суралцах чадвар нэмэгдсэн, 57% нь давтан үзэх боломжтой, 4.1% нь баяр жаргал нэмэгдсэн гэж үнэлсэн байна.

Цахим сургалтанд хамрагдаснаар оюутнуудад үзүүлж буй эрэг нөлөөг хүйсийн байдлаар харьцуулан судлахад эрэгээр нөлөөлж байна хэмээн үзэж байгаа оюутнуудын дунд эмэгтэй оюутнуудын эзлэх хувь өндөр буюу статистик ач холбогдол бүхий ялгаатай P<0.000 байна. (Хүснэгт 5)

Хүснэгт 5. Цахим сургалтанд хамрагдаснаар оюутанд үзүүлэж буй эерэг нөлөөг судалсан дүн (хүйсээр)

Цахим сургалтын эерэг нөлөө	Хүйс				P утга
	Эрэгтэй		Эмэгтэй		
	n	%	n	%	
Бие даан суралцах чадвар нэмэгдсэн	149	37.1%	331	56%	0.000
Давтан үзэх боломжтой	106	26%	334	57%	0.000
Баяр жаргал нэмэгдсэн	47	12%	24	4%	0.000

Хэлцэмж: Бидний судалгааны үр дүнг бусад судалгааны үр дүнтэй харьцуулан судаллаа. Elshami W нарын Шархажийн Их Сургуулийн Анагаах Ухаан, Эрүүл Мэндийн Шинжлэх Ухааны Коллежийн оюутан болон багш нарын дунд 2020 онд хийсэн цахим сургалтын сэтгэл ханамжид нөлөөлж буй хүчин зүйлсийг судалсан судалгааны үр дүнгээс үзэхэд нийт судалгаанд хамрагдагсдын 68.7% нь цахим сургалтанд сэтгэл хангалуун бус байсан бол бидний судалгаагаар 82.2% нь цахим сургалтанд сэтгэл ханамжтай байна. Мөн дээрх судалгааны үр дүнгээс үзэхэд цахим сургалтын сэтгэл ханамжийг хүйсийн байдлаар харьцуулан судлахад P=0.88 буюу статистик ач холбогдол бүхий ялгаагүй байсан бол бидний судалгаагаар цахим сургалтын сэтгэл ханамжийн байдлыг хүйсээр харьцуулан судлахад статистик ач холбогдол бүхий ялгаатай P<0.001 байна.

Alaa Zuhir нарын 2019 онд Арабын Нэгдсэн Эмират Улсын Ажман Их Сургуулийн оюутнуудын дунд цахим сургалтын давуу болон сул талуудыг судалсан судалгааны үр дүнгээс үзэхэд 73% нь цахим сургалтын сул тал нь нийгмээс тусгаарлагдах байдал гэж үзэсэн бол бидний судалгаагаар 52% нь цахим сургалтанд цаг их зарцуулж байгаа нь сул тал гэж үнэлсэн байна.[6]

Encarnacion R нарын 2021 онд хийгдсэн судалгаанаас үзэхэд 76.4% нь цахим сургалтанд хамрагдасанаар суралцах сонирхол нэмэгдсэн, дүн шинжилгээ хийх, шийдвэрлэх, онлайн асуултуудад хариулах, даалгавар, төсөл илгээх зэрэг ур чадвараа дээшлүүлэхэд эерэгээр нөлөөлж байна гэж үзсэн бол бидний судалгаагаар 57% нь бие даан суралцах чадвар нэмэгдсэн нь эерэг нөлөө гэж үзжээ.[7]

Дүгнэлт:

1. Судалгаанд хамрагдагсдын дийлэнх буюу 82.5% нь цахим сургалтанд сэтгэл ханамжтай байна. Оюутнуудын дийлэнх нь цахим сургалтанд хамрагдахад (40%) 5 ба түүнээс дээш цаг зарцуулдаг бол бэлтгэл хангахад (31.2%) 1-2 цаг зарцуулдаг байна. Цахим сургалтанд хамрагдахад цаг их зарцуулж байгаа нь зонхилох бэрхшээл болж байсан (52.9%) бол бие даан суралцах чадвар нэмэгдсэн (48.5%) нь зонхилох эерэг нөлөө байжээ.
2. Судалгаанд хамрагдагсдын цахим сургалтын сэтгэл ханамжийн түвшин, сургалтанд хамрагдахад болон бэлтгэл хангахад зарцуулж буй цаг, сургалтанд хамрагдахад тулгарч буй бэрхшээл болон эерэг нөлөө зэргийг насны бүлэг, хүйсийн байдлаар харьцуулан судлахад статистик ач холбогдол бүхий ялгаатай P<0.05 байсан бол тулгарч буй бэрхшээлүүдээс багаар ажиллах чадвар буурсан үзүүлэлт нь насны хувьд статистик ач холбогдол бүхий ялгаагүй P>0.05 байна.

Ном зүй:

1. *Б.Буяндэлгэр, Ш.Мөнхбат, Б.Гэрэлмаа, Б.Баярсайхан, (2022). Мэргэжлийн боловсрол, сургалтын байгууллагын суралцагчдын цахим сургалтын бэлэн байдлын судалгааны үр дүн. Боловсролын судалгааны монголын сэтгүүл, 27[1]*
2. *Ж.Төгсөө, Т.Оюун-Эрдэнэ, С.Сайнзаяа, Танхим болон цахим хосолсон сургалтын онол, арга зүйн зарим асуудал 2020. Vol.04, HUM 2 [2]*
3. *Б.Угангэрэл, Цахим сургалтын хөгжүүлж буй туршлага АНУ, БНСУ болон монголын жишээн дээр, монгол хүн амын сэтгүүл, 2013 [3]*
4. *Т.Уранчимэг, С.Базаррагчаа, Э.Сэлэнгэ, Цахим сургалт: Эм зүй мэргэжлийн онлайн сургалтыг sure аргачлалаар үнэлсэн туршилт, судалгаа. 2021 [4]*
5. *Elshami W, Taha MH, Abuzaid M, Saravanan C, Al Kawas S, Abdalla ME. Satisfaction with online learning in the new normal: perspective of students and faculty at medical and health sciences colleges. Med Educ Online. 2021;26:1920090[5]*
6. *Alaa Zuhir Al Rawashdeh, Enaam Youssef Mohammed, Asma Rebhi Al Arab, Mahmoud Alara and Butheyna Al-Rawashdeh, Advantages and Disadvantages of Using e-Learning in University Education: Analyzing Students' Perspectives 108-117 [6]*
7. *Encarnacion, R. E., Galang, A. D., Hallar, B. A. (2021). The impact and effectiveness of e-learning on teaching and learning. International Journal of Computing Sciences Research, 383-397 [7]*
8. *Rovai, A. (2002). Building sense of community at a distance. International Review of Research in Open and Distance Learning .*
9. *Salcedo, C. S. (2010). Comparative analysis of learning outcomes in face-to-face foreign language classes vs. language lab and online. J. Coll. Teach. Learn. 43–54.*
10. *Poon, J. (2013). Blended Learning: An Institutional Approach for Enhancing Students' Learning Experiences. MERLOT Journal of Online Learning and Teaching.*

Students of Ulaanbaatar city A grade that describes the state of e-learning

Myagmarchimeg Ch[1], Bilegt B[2], Tamiraa Ts[3]

[1,2]School of Health, Etugen University
[3]School of Public Health, MNUMS
E-mail: chimgeemerik@gmail.com, Tel: +976-99227877

Background: The rapid development of technology has completely changed the way we live, learn, and work, and it has forced us to abandon traditional methods as much as possible and use innovative methods to be more flexible and adapt quickly.
Aim: The purpose of this research work was to search the e-learning status of student in Ulaanbaatar city and the factors affecting it.
Materials and Methods: This searching were included randomly 990 students of Ulaanbaatar city. The study was evaluated with a 30-question questionnaire, a one-and two-sample T-test, and a multivariate test. Data were analyzed descriptively (calculation of percentage and frequency).
Results: The majority of respondents, 82.5%, are satisfied with e-learning. The most of the students spend 5 or more hours on e-learning (40%), and 1-2 hours on preparation (31.2%). Spending a lot of time to participate in online learning was at a lowest level (52.9%), while increased self-learning ability (48.5%) was the highest positive effect.
Conclusion: When comparing the respondents' level of satisfaction with online learning, the time spent on training and preparation, and the difficulties and positive effects of training by age group and gender, there was a statistically significant difference $P<0.05$. There is no statistically significant $P>0.05$ difference in decreasing team work ability from the problems they faced.
These findings are valuable for the government, school administrators, teachers and parents to acknowledge the importance of well-equipped facilities and a stable internet connection for effective learning. However, it is recommended for future researchers to utilize a larger sample size and students from various backgrounds to better understand this issue.

Keywords: Satisfaction, The time spent on training, The time spent on preparation, Difficulties, Positive effects